# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ

# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төрийн байгууллага:134

Төрийн албан хаагчид: 3270

- Эмэгтэй 71.8%
- Эрэгтэй 29.1%

- Удирдах 8.7%
- Гүйцэтгэх 69.7%
- Туслах 21.5%

- ТҮ 80%
- ТЗ 12%
- ТТ 5%
- ТУ 3%

# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Төрийн албаны **ерөнхий шалгалт** зохион байгууллаа

Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2 өдөр 16 ээлжээр 194 хүнийг хамруулан 3 түвшингээр зохион байгуулж, шалгалтад 62 иргэн тэнцэж төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдлээ.



Төрийн албаны **тусгай шалгалт** зохион байгууллаа

Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалтад Сайнцагаан, Говь-Угтаал, Дэрэн сумдын ЗДТГ-ын дарга нарын сул орон тоо нөхөгдөж, 11 мэргэжилтний сул орон тоонд шалгуулагчид тэнцэж холбогдох ажилдаа нэр дэвшин томилогдлоо.

# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 оны 06 дугаар сарын байдлаар 13 сумын 41 ажлын байр, 14 байгууллагын 82 ажлын байрны захиалгыг шаардлагын дагуу холбогдох баримтыг нягтлан хүлээн авч сонгон шалгаруулалт зарлахад бэлэн болголоо. Ковид-19 цар тахалын улмаас шалгалт зарлах хугацаа тодорхойгүй байна.

**119**

Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаал

**13**

Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагч

**8**

Төрийн захиргааны удирдах албан тушаал

# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүнээр нөхөн томилогдлоо.



**Салбар зөвлөлийн гишүүн, Цагдаагийн газрын дарга**



**Салбар зөвлөлийн гишүүн, Сайнцагаан сумын ЗДТГ-ын дарга**



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 28 өдөр Дугаар 136 Улаанбаатар хот

Салбар зөвлөлийн
гишүүнээс чөлөөлж, томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2.4, 5.12 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн гишүүн Л.Баярсайхан, Б.Оюунчимэг нар нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдсөн тул 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс Салбар зөвлөлийн гишүүнээс чөлөөлж, мөн өдрөөс аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа Г.Наранбаатар, Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Лхагвасүрэн нарыг Салбар зөвлөлийн гишүүнээр томилсугай.

2.Төрийн албаны тухай хууль тогтоомж, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

3.Тус салбар зөвлөлийн гишүүдийг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж буй байдалд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь Салбар зөвлөлийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Мөнгөнцоож/-д даалгасугай.

ДАРГА Б.БААТАРЗОРИГ

2021.04.28-ны өдрийн
№136 тогтоолоор

# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нийт-87 албан хаагчийг сургасан байна

**УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН СУРГАЛТ**




Мэргэшүүлэх багц болон дунд хугацааны сургалт -10
Анх орсны -8






Эрхэлсэн түшмэл –2
Ахлах түшмэл -4




Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт үнэлгээ “Алсын хараа-2050” -63



# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

**Цахим сургалтын сэдэв**

- Төрийн албаны болон архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилт
- Судалгаанд суурилсан төрийн албаны шинэтгэл
- Зан үйлд төлөөлөх ухааныг төрийн бодлогод ашиглах нь
- Төрийн албан хаагч иноваци нэвтрүүлэгч байх нь
- Төрийн удирдлагын инновацид загварчлалын сэтгэлгээний аргачлал ашиглах нь
- Цахим орчинд ажиллаха үүсэх эрүүл мэндийн асуудал
- Кибер орон зай дахь аюулгүй байдал
- Орчин үе дэх техник технологийн чиг хандлага
- e-mongolia цахим мэдээллийн систем
- Өөрчлөлтөд дасан зохицож удирдах нь

**Цахим сургалтын сэдэв**

- Харилцан хүндэтгэл, итгэлцэл бүхий орчин бүрдүүлэх нь
- Албан хаагчийн идэвх оролцоог нэмэгдүүлэх нь
- Сэтгэл хөдлөлөө удирдах нь
- Монгол улсын төрийн албан дахь жендэрийн тэгш байдлыг хангах хүрээ
- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн гишүүдийг чадавхижуулахад чиглэсэн гарын авлага
- Төрийн үйлчилгээний чанар
- Төрийн байгууллагад зан үйлийн менежментийг хэрэгжүүлэх нь
- Төрийн байгууллага дахь ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахад удирдлага ба нийтийн албан тушаалтны үүрэг
- Монгол төрийн түшмэдийн уламжлал, ёс суртахууны асуудал

**Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 19 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 400-аад албан хаагчдыг хамрууллаа.**

# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Төрийн захиргааны тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдын сургалтын судалгаа
2. Төрийн албанд 2021 онд томилогдсон албан хаагчийн судалгаа
3. Төрийн байгууллагуудын 2019-2021 оны ёс зүйн зөвлөлийн мэдээлэл
4. Төрийн албан хаагчийн ажилласан жилийн нэгдсэн тоо бүртгэлийн судалгаа
5. Тусгай шаардлага хангаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын судалгаа
6. Төрийн захиргааны албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа албан хаагчдын судалгаа
7. Төрийн албанаас чөлөөлөгдсөн, түр чөлөөлөгдсөн албан хаагчдын судалгаа
8. Төрийн албанаас халагдсан албан хаагчдын судалгаа
9. Албан тушаал бууруулсан албан хаагчдын судалгаа
10. Төрийн албаны удирдах албан тушаалын нэгдсэн тоо бүртгэл
11. Шагнал, урамшуулал авсан албан хаагчдын судалгаа
12. Сургалтад хамрагдсан албан хаагчдын судалгаа
13. Төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэвийн судалгаа
14. Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн судалгаа
15. Шилжин болон сэлгэн ажилласан төрийн албан хаагчдын судалгаа
16. Эрхэлсэн түшмэлээс тэргүүн, ахлах түшмэлээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд дэвшин ажиллах боломжтой эмэгтэйчүүдийн судалгаа



Нийт 16 төрлийн судалгааг 15 сум, 22 агентлагаас гарган авч ТАЗ-д хүргүүллээ.

# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Бодлогын 2 баримт бичиг боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж аймгийн ЗДТГ-т хүлээлгэн өглөө.



ЗАХИРАМЖ

2021 ... 06 ... 19 ... Дугаар А/... ... Мандалговь

Дундговь аймгийн
"Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан "Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", 15 дугаар тогтоолоор батлагдсан "Дундговь аймгийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөө", аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн "Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хавсралтаар батлсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, хөтөлбөрийн хэрэгжилт болон жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гарган аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлж байхыг хэлтэс, агентлагийн дарга, сум, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ...

Дундговь аймгийн "Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"



Төрийн захиргааны байгууллагад шинээр томилогдсон
албан хаагчийг чиглүүлэх, үйл ажиллагаанд дадлагажуулах
журам батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн "Төрийн захиргааны байгууллагад шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх, үйл ажиллагаанд дадлагажуулах журам"-ыг хавсралтаар батлсугай.

Хоёр. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст, журмыг үр дүнтэй хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. "Цахим хөтөч цүнх"-нд байх баримт бичгийн жагсаалтыг өөрийн байгууллагын албан ёсны цахим хуудаст тусгайлан хавтас нээж байршуулахыг төрийн захиргааны төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

Төрийн захиргааны байгууллагад шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх, үйл ажиллагаанд дадлагажуулах журам

# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН




- Төрийн захиргааны албаны зэрэг дэв авах албан хаагчдын материалыг сум, байгууллагуудаас хүлээн авч нэгтгэн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 87 албан хаагчид зэрэг дэв шинээр болон ахиулан олгох хүсэлтийг аймгийн Засаг даргад өргөн барьлаа. Улмаар аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 24-ны А/68 дугаар захирамжаар 8 сум, 14 байгууллагын 87 албан хаагчид зэрэг дэв олголоо.

  Үүнээс 30 албан хаагч шинээр зэрэг дэв авсан байна.

- Төрийн албаны зөвлөлийн хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтнын дагуу аймгийн Төв халхын дуулалт жүжгийн театр, Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр, Номын сан, Музей, сумдын Соёлын төвийн даргын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/88 дугаар захирамжаар батлууллаа.